

КҮРТИН Жеремиа  
(1835 - 1906)



Америкийн их номын хүн Ж. Күртин (Jeremiah CURTIN)-ийг нас барсаны нь хойтон жилээс эхлэн

“Монголчууд: Түүх нь” (Jeremiah Curtin, *The Mongols: A History*, Boston, 1907, 426 p.),

“Орос дахи Монголчууд” (Jeremiah Curtin, *The Mongols in Russia*, Boston, 1908, XX + 481 p.),

“Сибирийн өмнөд биеэр аялсан нь” (Jeremiah Curtin, *A Journey in Southern Siberia: The Mongols, Their Religions and Their Myths*, London, 1909, 319 pp. , + illus.)

гэдэг хэдэн зуун хуудастай, зураг хөрөг бүхий гурван боть томоохон бүтээл нь хэвлэгджээ. Энэ гурван номыг АНУ-д Монголын талаар гарсан хамагийн анхны бүтээл бөгөөд тус улс дахи монголын судлалын эхийг тавьсан гэж үздэг юм.

Ж. Күртиний бүтээлийн эхний ботид тухайн үеийн АНУ-ын ерөнхийлөгч Теодор Рүзвельт (Theodore Roosevelt) эрдэм шинжилгээний чанартай томоохон оршил бичсэн бөгөөд үүндээ зохиогч болон монголчуудын гайхамшигт түүхийн талаар бахдан тэмдэглэсэн нь америкийн олон нийтэд Монгол болон монголчуудын түүхийн тухай анхны тодорхой мэдэлгийг өгчээ. Ерөнхийлөгч Т. Рүзвельт “Оршил”-оо “Ж. Күртин нас барсанаар эрдэм чадал хэтийдсэн хоёр гуравхан эрдэмтэний нь нэгийг Америкаас аваад явчихлаа...” хэмээн эмгэнэн эхилүүлсэн нь жараад хэл мэддэг энэ бичигийн их хүмүүн ямар хүн байсаныг нь бэлхэнээ гэрчилдэг юм.

Эрдэм суртал гүн хэмээн олон түмэний хүлээн зөвшөөрдөг ерөнхийлөгч Т. Рүзвельт “...Монголын ард түмэний түүхийг бүрэнээ мэдэх нь Ази хийгээд дорнод Европын хөгжил мандалыг ойлгоё гэсэн хэн бүхэнд зайлашгүй чухал болно. Ж. Куртинийхи шиг тийм түүхийг англиар туурвисан өөр хүн үгүй гэж хэлвэл зохино ...” хэмээн 1907 оны 9-р сарын нэгэнд бичсэн оршилоо өндөрлөжээ (Уг оршилыг англи эхээр нь ард хавсаргаж, Э. Мөнх-Учралын орчуулгыг дагалдуулав).

19 бөлөг бүхий “Монголчууд: түүх нь” хэмээх эхний ботидоо зохиогч орос, хятад, араб, перс сурвалжийн одоо ч гэсэн олон түүхэчийн сайн мэдэхгүй баримт хэрэглэгдэхүүнд үндэслэж Чингис хаанаас Тогоонтөмөрийг хүртэлхи Монголын түүхийг багтаажээ ( Энэ ботид өөрийнхи нь бичсэн танилцуулгыг уг эхээр нь хавсаргав).

20 бөлөг бүхий “Орос дахи Монголчууд” хэмээх хоёрдугаар боть нь бараг Оросын түүхэнд хамаарах боловч Монголын эзэмшилын үед холбогдох хэсэг нь Монголын түүхэнд шууд холбогдоно.

Ж. Куртин номынхоо “Сибирийн өмнөд биеэр бядан явсан тэмдэглэл” гэдэг гутгаар ботид Монголчуудын шашин суртахуунд холбогдох мэдээ баримт хийгээд үлгэр домог тэргүүтэнийг багтаасан бөгөөд үүндээ “Гэсэрийн тууж” зэрэг бичигийн баримтаас гадна Буриад Монголд хоёр сар аялах үедээ цуглуулсан баримт хэрэглэгдэхүүнээ өргөн ашиглаж англиар орчуулан танилцуулсан байдаг. Энэ нь монголчуудын аман зохиолыг судлаж, англи хэлээр анх түрүүн гаргасан бүтээл гэж эрдэмтэд үнэлэн тэмдэглэсэн байдаг. Үүнээс гадна энэ ботид орсон монголчуудын хуримлах ёс зэрэг зан заншил, бөөгийн судлалд холбогдох маш сонин баримтууд нь дараа дараагийн судлагчидад судлагааны хэрэглэгдэхүүн болох ач холбогдолтойг онцлон тэмдэглэвэл зохилтой.

Ц. Шагдарсүрэн

Хавсралт зурагийн тайлбар:

Зураг № 1. Их бичигийн хүн Жеремиа Куртин

Зураг № 2. Ж. Куртины “Монгол: Түүх нь” гэдэг номын хоёрдугаар хэвлэлийн дотор нүүр болон зохиогчийн бичсэн танилцуулгын эх

Хавсралт: АНУ-ын ерөнхийлөгч Т. Рүзвельтийн бичсэн оршилын уг эх.

# THE MONGOLS

## A HISTORY

BY  
JEREMIAH CURTIN

AUTHOR OF "MYTHS AND FOLK-LORE OF IRELAND," "HERO-TALES  
OF IRELAND," "MYTH AND FOLK-TALES OF THE RUSSIANS,  
WESTERN SLAVS, AND MAGYARS," "CREATION MYTHS  
OF PRIMITIVE AMERICA," ETC.

*With a Foreword by*  
**THEODORE ROOSEVELT**



GREENWOOD PRESS, PUBLISHERS  
WESTPORT, CONNECTICUT

**T**HEODORE ROOSEVELT, *President of the United States of America.* I dedicate to you the present volume entitled "*The Mongols, a History.*" I do this because on September 5th, 1901, in the city of Burlington where you addressed Vermont veterans, I asked permission to make the dedication and you gave it. You were Vice-President at that time.

I made this request because I have great respect and admiration for you as a man, as a leader of men, and a scholar; and because of the way in which I came first to know you.

In 1891 you, as Chairman of the Civil Service Commission, were in Washington. I had just returned to that city from a work of two years among Pacific Coast Indians. Of these, two tribes in California had asked me to intercede for them with the President, who in those days was Benjamin Harrison. These Indians were among the truly wretched and suffering. One tribe of them had been almost exterminated through a massacre inflicted by white men. The other reduced to a feeble remnant through various man-killing processes. Still they were worthy of earnest attention. Their myths have a beauty and a value which should preserve them till literature perishes. These two tribes were the Wintu and the Yana whose account of the world and its origin I published later on in "*Creation Myths of Primitive America.*"

On reaching Washington I went to Frederick T. Greenhalge, my classmate, who then represented a part of Massachusetts in Congress, but afterward was one of that Commonwealth's renowned governors. Greenhalge tried to induce a strong man or two from the Senate or House to assist us to act on the President, but, though promises were made, no man came with support, and we went alone to the White House. The case had been stated clearly on two pages which I held ready for delivery. When I had given the reason

v

of my coming the President answered: "I see no way to help you. What can I do in this matter?" "You can give," replied I, "the executive impulse. Send this statement to the Secretary of the Interior, and direct him to act on it." "That will suffice," added Greenhalge. "I will do it," said the President, after thinking a moment. He took my paper, jotted down the directions I had suggested, and sent them to the Secretary.

We came away greatly satisfied, and halted some moments at the head of the staircase. The President's chamber was on the second story. All at once in the large room below us I saw a young man, alert in his bearing and perfectly confident. He gazed at the ceiling and walls of the room, and was thoroughly occupied. There was no one else in the apartment. I asked Greenhalge to look at him. "That man," said I, "looks precisely as if he had examined this building, and finding it suitable has made up his mind to inhabit it." "He is a living picture of that purpose," replied Greenhalge. "But do you not know him? That is Theodore Roosevelt, Chairman of the Civil Service Commission, I must make you acquainted. But first listen to a prophecy: That man down there who wants this house will get it. He will live here as President."

On reaching the foot of the staircase Greenhalge met you and made us acquainted. We conversed for some moments, and then you were called to the President. You and I did not meet for some years after that day at the White House. You were toiling at problems of government and service, looking ahead always, looking to things over which you are brooding and toiling this moment. Some of the problems have been solved, others still demand solution.

My work led me to various parts of the earth, and around it. But at home or abroad I watched your activity with care and deep interest. Not very long after that prophecy I read for the first time this statement concerning you: "We need just such a man to be President." These words, uttered casually at that juncture, were like the still small voice, their might was in their quality.

When a few years of service, unique in many ways, had brought you to the Navy you accomplished your task in that place and went farther immediately. By this time your name and the office of President were associated in the minds of many people. Next came the Cuban war with experience and triumph. And then you

## Dedication

vii

*were governor at Albany. While still in that office you were named for Vice-President, and elected. Later you were President. But only when elected by the people could you act as seemed best to you and not as antecedents commanded.*

*I have watched and studied your career with deeper interest than that of any man who has ever been President of the United States. There is no case in our history of such concordance between the judgment of a people and the acts of a man. "Thou hast been faithful over a few things, I will make thee ruler over many."*

*Jeremiah Curtin.*

ST. HYACINTHE, P. Q., September 6, 1906.

## Монголчууд: Түүх нь

### Жеремиа КҮРТИН

(Ирландын ардын аман зохиол домог, Ирландын баатарлаг үлгэрүүд,  
Орос, Өрнөд Слав, Мажсар ардын үлгэр болон домгууд,  
Балар эртний Америкийн домог туурвил зэрэг номын зохиогч)

Өмнөх үгийг Теодор Рүүзвелт бичив.

Гринвүүд хэвлэлийн газар  
Вестпорт, Коннектикат

Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч Теодор Рүүзвелт<sup>1</sup> танаа “Монголчууд, Түүх нь” хэмээх энэхүү номоо зориулж байна. Ийнхүү өргөн барьж буй нь 1901 оны 9 сарын 5-ны өдөр Бүрлингтоны хотод Вермонтын ахмад дайчидтай уулзах үеэр тань би өмнөтгөл бичих зөвшөөрөл эрж, та ч бичиж өгсний учир билээ. Тэр үед та дэд ерөнхийлөгч байсан сан.

Таныг эр хүн, эрчүүдийг манлайлан тэргүүлэгч, эрдэмтэн болохын хувьд сэтгэлийн угаас гүнээ бишрэн хүндэтгэдэг хийгээд мөн таныг анхлан мэдэх болсон тэрхүү хувь тохиоллын улмаас би энэ хүсэлтээ тавьж байгаа юм.

1891 онд “Иргэний үйлчилгээний хороо” -ны тэргүүн та Вашингтонд байж билээ. Би Номхон далайн эргийн индианчуудын дунд хоёр жил ажиллаад Вашингтонд дөнгөж ирчихээд байв. Калифорнийн хоёр омгийнхон надаас тухайн цагт ерөнхийлөгч асан Бенжамин Харрисонтой уулзаж ахуй байдлаа мэдүүлж өгөхийг хүссэн юм. Тэдгээр Индианчууд үнэхээр хүнд хэцүү, зовлон шаналанд автан амьдарч байв. Нэг овог нь цагаан арьстнуудын аллага хядлагад өртсөөр бараг устаж үгүй болохдоо тулж, нөгөө нь янз бүрийн үхлийн аюултай үйлдлийн улмаас тэнхээ тасарсан үлдэл хоцрол төдий болсон байлаа. Тэдэнд онцгой анхаарал халамж хандуулах хэрэгтэй байсаар. Тэдний үлгэр домгууд маш уран сайхан, үнэ цэнэтэй юм. Ийм утга зохиолыг мөхөж сөнөхөөс нь урьтан хадгалж хамгаалууштай. Винтү, Яна хэмээх энэ хоёр аймгийн аж амьдрал, үүсэл гарлын тухай би сүүлд “Балар эртний Америкийн домог туурвил”<sup>2</sup> номдоо нийтэлсэн.

Вашингтонд хүрээд ангийн анд, хожим Конгресст Массачусетсийг төлөөлж, дараа нь “Хамтын нөхөрлөл”-ийн алдартай амбан захирагч болсон Фредерик Т.

<sup>1</sup> Теодор Рүүзвелт – (Theodore Roosevelt, 1858-1919) - Америкийн Нэгдсэн Улсын 26 дахь ерөнхийлөгч.

<sup>2</sup> Балар эртний Америкийн домог туурвил - (Creation Myths of Primitive America) 1898 онд хэвлүүлсэн.

Грийнхалж<sup>3</sup> дээр очлоо. Тэр бээр Сенат юм уу Цагаан ордноос ерөнхийлөгчтэй уулзахад минь дөхөмчилж чадахуйц эрх мэдэл бүхий нэг хоёр хүн олохыг оролдов. Хэдийгээр амласан боловч хэн ч тусалж дэмжихээр ирсэнгүй. Тэгээд бид хоёулхнаа Цагаан Ордон руу явлаа. Миний хүргэж өгөхөөр барьж яваа хоёр хуудаснаа нөхцөл байдлыг тов тодорхой өгүүлсэн байв. Ирсэн хэрэг зориг минь болох бичгээ өргөн барихад Ерөнхийлөгч *“Би танд хэрхэн тус болохоо мэдэхгүй байна. Би юу хийж чадах вэ?”* гэсэн хариу өглөө. *“Та чадна аа”* гэж би хэлээд, *“Гүйцэтгүүлэх түлхэц. Та энэ мэдэгдлийг Дотоод хэргийн нарийн бичгийн даргад илгээж, түүнд хэрэг явдлыг шийдэхийг тушаана уу”* гэв. *“Энэ л хангалттай”* гэж Грийнхалж хажуугаас нэмж хэллээ. Ерөнхийлөгч хэсэг бодолхийлснээ *“Тэгье”* гээд цаасыг авч, миний санал болгосноор заавар бичиж Нарийн бичгийн дарга руугаа илгээж билээ.

Бид хоёр сэтгэл нэн хангалуун гарч ирээд шатны эхэнд хэсэг зогсонолоо. Ерөнхийлөгчийн өрөө хоёр дугаар давхарт байдаг. Доод давхрын том өрөөнд бүхий л дүр төрхөөрөө бүрэн дүүрэн итгэлтэй байдлыг илтгэсэн нэгэн залуу эр байхыг би олж харлаа. Тэр бээр өрөөний хана, таазыг тун гярхай ажиглан ширтэж байв. Өрөөнд өөр хэн ч байсангүй. Би Грийнхалжийг түүн рүү харахыг хүсээд *“Тэр эрэгтэй... яг л эндэхийг сайтар иинжснэ, тохирох юм байна гэдгийг олж мэдээд, энд амьдрахын тулд оюун бодлоо хөвчилж байх шиг харагдах юм”* гэхэд Грийнхалж *“Тэр бол энэ зорилгын амьд зураг”* хэмээн хариулж билээ. Тэгээд *“Ингэхэд чи түүнийг танихгүй юу? Иргэний үйлчилгээний хорооны тэргүүн Теодор Рүүзвелт. Би чамайг танилцуулж өгье. Гэхдээ эхлээд нэг зөн таамгийг сонс. Юу гэвэл, доор байгаа эр бол энэ ордныг авахыг хүсэж буй хүн. Тэр Ерөнхийлөгч болж, энд суух болно”* гэсэн юм.

Шатаар буугаад Грийнхалж тантай уулзаж, биднийг танилцуулав. Бид хэдэн хором ярилцаж билээ. Дараа нь та *“Ерөнхийлөгч”* гэж дуудуулах болсон. Тэр өдөр Цагаан ордонд уулзсанаас хойш хэдэн жил бид тааралдаагүй. Энэ үед та засгийн газрын, үйлчилгээний өдий төдий бэрхшээлийг шийдвэрлэх гэж шургуу ажиллаж, үргэлж ирээдүйг харж, бие сэтгэлээ чилээж, нөр хичээнгүйгээр хүчин зүтгэж байсан. Тэдгээрээс зарим нь шийдвэрлэгдэж, зарим нь хариу шаардсаар бүлгээ.

Би ажлаар дэлхий тойрон, янз бүрийн газар оронд очиж байлаа. Гэхдээ гэртээ ч, хилийн чанадад ч таны явуулж буй бодлого, үйл хэргийг ихэд сонирхон анхаарч үздэг байсан. Тэрхүү зөн бэлгийг сонссоноос хойш төдийлөн удалгүй, танд хамаарах *“Бидэнд ердөө Ерөнхийлөгч болох тийм хүн хэрэгтэй байна”* гэсэн мэдэгдлийг анх уншиж билээ. Тухайн үеийн нөхцөл байдлын уулзар дээр санамсаргүй гарсан эдгээр үгс энгийн хэдэн үг, ялимгүй дуу хоолой мэт боловч түүний хүч чадал нь утга учир, мөн чанартаа оршиж байсан юм.

Үйлчилгээний албанд зүтгэсэн тэр хэдэн жилээс олон талаараа ер бусын нэг нь таныг өөрийн зорилгоо биелүүлж, цааш шулуухан явсан дардан зам болох тэнгисийн цэрэгт авчирчээ. Энэ үеэс таны нэр, ерөнхийлөгчийн албан тушаал хоёр олон хүний бодол санаанс салахгүй болсон юм. Дараа нь аугаа ялалт, асар их дадлага туршлага дагуулсан Кубын дайн боллоо. Улмаар та Албанид амбан захирагчаар томилогдож, энэ

<sup>3</sup> Фредерик Т. Грийнхалж – (Frederic T. Greenhalge, 1842-1896)



тушаалд байхдаа дэд ерөнхийлөгчид нэр дэвшиж, сонгогдов. Хожим та Ерөнхийлөгч болсон. Гэхдээ ард иргэдээс сонгогдох үедээ та өөртөө хамгийн сайн санагдаж байхаар хийж гүйцэтгэсэн нь урьдасынхины захирч тушаадаг шиг байгаагүй билээ.

Би таны ажил хэрэг, амжилт бүтээлийг урьд өмнө Америкийн нэгдсэн улсын ерөнхийлөгч байсан хэн хүнийхээс илүү ихээр сонирхон анхаарч байдаг. Бидний түүхэнд хүмүүний үйл хэрэг болон хүн ардын шүүлэг хоорондын зохицол мэтийн зүйл байгаагүй. *“Та хэд хэдэн зүйл дээр үнэнхүү итгэлтэй байж ирсэн. Би жолоодогч танд илүү ихийг даатгаж байна”*

*Жеремиа КҮРТИН*

*Гэгээн Хясинте<sup>4</sup>, П. К,  
1906 оны 9 сарын 6*

---

<sup>4</sup> Гэгээн Хясинте, П. К – (St. Hyacinthe, P. Q) – Монреалын зүүн хэсэг дэх Кюбекийн баруун өмнөдод орших хот. 1849 онд тосгон болох үед хүн ам нь 10.200 байсан бөгөөд жилийн дараа жижиг хот болж, 1857 онд хот болон хөгжсөн.

## FOREWORD

---

THE death of Jeremiah Curtin robbed America of one of her two or three foremost scholars. Mr. Curtin, who was by birth a native of Wisconsin, at one time was in the diplomatic service of the Government; but his chief work was in literature. The extraordinary facility with which he learned any language, his gift of style in his own language, his industry, his restless activity and desire to see strange nations and out of the way peoples, and his great gift of imagination which enabled him to appreciate the epic sweep of vital historical events, all combined to render his work of peculiar value. His extraordinary translations of the Polish novels of Sienkiewicz, especially of those dealing with medieval Poland and her struggles with the Tartar, the Swede and the German, would in themselves have been enough to establish a first class reputation for any man. In addition he did remarkable work in connection with Indian, Celtic and other folk tales. But nothing that he did was more important than his studies of the rise of the mighty Mongol Empire and its decadence. In this particular field no other American or English scholar has ever approached him.

Indeed, it is extraordinary to see how ignorant even

ix

the best scholars of America and England are of the tremendous importance in world history of the nation-shattering Mongol invasions. A noted Englishman of letters not many years ago wrote a charming essay on the Thirteenth Century — an essay showing his wide learning, his grasp of historical events, and the length of time that he had devoted to the study of the century. Yet the essayist not only never mentioned but was evidently ignorant of the most stupendous fact of the century — the rise of Genghis Khan and the spread of the Mongol power from the Yellow Sea to the Adriatic and the Persian Gulf. Ignorance like this is partly due to the natural tendency among men whose culture is that of Western Europe to think of history as only European history and of European history as only the history of Latin and Teutonic Europe. But this does not entirely excuse ignorance of such an event as the Mongol-Tartar invasion, which affected half of Europe far more profoundly than the Crusades. It is this ignorance, of course accentuated among those who are not scholars, which accounts for the possibility of such comically absurd remarks as the one not infrequently made at the time of the Japanese-Russian war, that for the first time since Salamis Asia had conquered Europe. As a matter of fact the recent military supremacy of the white or European races is a matter of only some three centuries. For the four preceding centuries, that is, from the beginning of the thirteenth to the seventeenth, the Mongol and Turkish armies generally had the upper hand in any contest with European foes, appearing in Europe always as invaders and often as conquerors; while no ruler of Europe of their days had to his credit such

mighty feats of arms, such wide conquests, as Genghis Khan, as Timour the Limper, as Bajazet, Selim and Amurath, as Baber and Akbar.

The rise of the Mongol power under Genghis Khan was unheralded and unforeseen, and it took the world as completely by surprise as the rise of the Arab power six centuries before. When the thirteenth century opened Genghis Khan was merely one among a number of other obscure Mongol chiefs and neither he nor his tribe had any reputation whatever outside of the barren plains of Central Asia, where they and their fellow-barbarians lived on horseback among their flocks and herds. Neither in civilized nor semi-civilized Europe, nor in civilized nor semi-civilized Asia, was he known or feared, any more, for instance, than the civilized world of today knows or fears the Senoussi, or any obscure black mahdi in the region south of the Sahara. At the moment, Europe had lost fear of aggression from either Asia or Africa. In Spain the power of the Moors had just been reduced to insignificance. The crusading spirit, it is true, had been thoroughly discredited by the wicked Fourth Crusade, when the Franks and Venetians took Constantinople and destroyed the old bulwark of Europe against the Infidel. But in the crusade in which he himself lost his life the Emperor Barbarossa had completely broken the power of the Seljouk Turks in Asia-Minor, and tho Jerusalem had been lost it was about to be regained by that strange and brilliant man, the Emperor Frederick II, "the wonder of the world." The Slavs of Russia were organized into a kind of loose confederacy, and were slowly extending themselves eastward, making settlements like Moscow in the midst of various Finnish

peoples. Hungary and Poland were great warrior kingdoms, tho a couple of centuries were to pass before Poland would come to her full power. The Caliphs still ruled at Bagdad. In India Mohammedan warred with Rajput; and the Chinese Empire was probably superior in civilization and in military strength to any nation of Europe.

Into this world burst the Mongol. All his early years Genghis Khan spent in obtaining first the control of his own tribe, and then in establishing the absolute supremacy of this tribe over all its neighbors. In the first decade of the thirteenth century this work was accomplished. His supremacy over the wild mounted herdsmen was absolute and unquestioned. Every formidable competitor, every man who would not bow with unquestioning obedience to his will, had been ruthlessly slain, and he had developed a number of able men who were willing to be his devoted slaves, and to carry out his every command with unhesitating obedience and dreadful prowess. Out of the Mongol horse-bowmen and horse-swordsmen he speedily made the most formidable troops then in existence. East, west and south he sent his armies, and under him and his immediate successors the area of conquest widened by leaps and bounds; while two generations went by before any troops were found in Asia or Europe who on any stricken field could hold their own with the terrible Mongol horsemen, and their subject-allies and remote kinsmen, the Turko-Tartars who served with and under them. Few conquests have ever been so hideous and on the whole so noxious to mankind. The Mongols were savages as cruel as they were brave and hardy. There were Nes-

torian Christians among them, as in most parts of Asia at that time, but the great bulk of them were Shamanists; that is, their creed and ethical culture were about on a par with those of the Comanches and Apaches of the nineteenth century. They differed from Comanche and Apache in that capacity for military organization which gave them such terrible efficiency; but otherwise they were not much more advanced, and the civilized peoples who fell under their sway experienced a fate as dreadful as would be the case if nowadays a civilized people were suddenly conquered by a great horde of Apaches. The ruthless cruelty of the Mongol was practised on a scale greater than ever before or since. The Moslems feared them as much as the Christians. They put to death the Caliph, and sacked Bagdad, just as they sacked the cities of Russia and Hungary. They destroyed the Turkish tribes which ventured to resist them with the merciless thoroughness which they showed in dealing with any resistance in Europe. They were inconceivably formidable in battle, tireless in campaign and on the march, utterly indifferent to fatigue and hardship, of extraordinary prowess with bow and sword. To the Europeans who cowered in horror before them, the squat, slit-eyed, brawny horsemen, "with faces like the snouts of dogs," seemed as hideous and fearsome as demons, and as irresistible by ordinary mortals. They conquered China and set on the throne a Mongol dynasty. India also their descendants conquered, and there likewise erected a great Mongol empire. Persia in the same way fell into their hands. Their armies, every soldier on horseback, marched incredible distances and overthrew whatever opposed them. They struck down the

Russians at a blow and trampled the land into bloody mire beneath their horses' feet. They crushed the Magyars in a single battle and drew a broad red furrow straight across Hungary, driving the Hungarian King in panic flight from his realm. They overran Poland and destroyed the banded knighthood of North Germany in Silesia. Western Europe could have made no adequate defense; but fortunately by this time the Mongol attack had spent itself, simply because the distance from the central point had become so great. It was no Christian or European military power which first by force set bounds to the Mongol conquests; but the Turkish Mamelukes of Egypt in the West, and in the East, some two score years later, the armies of Japan.

In a couple of generations the Mongols as a whole became Buddhists in the East and Moslems in the West; and in the West the true Mongols gradually disappeared, being lost among the Turkish tribes whom they had conquered and led to victory. It was these Turkish tribes, known as Tartars, who for over two centuries kept Russia in a servitude so terrible, so bloody, so abject, as to leave deep permanent marks on the national character. The Russians did not finally throw off this squalid yoke until thirty years after the conquest of Constantinople by the Ottoman Turks, the power of the Tartars waning as that of the Ottomans approached its zenith. Poland was now rising high. Its vast territory extended from the Baltic to the Black Sea. It was far more important than Muscovy. In the "Itinerary" of that widely travelled Elizabethan, Fynes Morrison, we learn that the Turks dreaded the Polish armies more than those of Germany,

or of any other nation; this was after the Hungarians had been conquered.

The scourge of the Mongol conquests was terrible beyond belief, so that even where a land was flooded but for a moment, the memory long remained. It is not long since in certain churches in Eastern Europe the litany still contained the prayer, "From the fury of the Mongols, good Lord deliver us." The Mongol armies developed a certain ant-like or bee-like power of joint action which enabled them to win without much regard to the personality of the leader; a French writer has well contrasted the great "anonymous victories" of the Mongols with the purely personal triumphs of that grim Turkish conqueror whom we know best as Timour the Tartar, or Tamerlane. The civil administration the Mongols established in a conquered country was borrowed from China, and where they settled as conquerors the conduct of the Chinese bureaucracy maddened the subject peoples almost as much as the wild and lawless brutality of the Mongol soldiers themselves. Gradually their empire, after splitting up, past away and left little direct influence in any country; but it was at the time so prodigious a phenomenon, fraught with such vast and dire possibilities, that a full knowledge of the history of the Mongol people is imperatively necessary to all who would understand the development of Asia and of Eastern Europe. No other writer of English was so well fitted to tell this history as Jeremiah Curtin.

THEODORE ROOSEVELT.

SAGAMORE HILL, *September 1, 1907.*



## ӨМНӨХ ҮГ

Жеремиа Күртиний нас барсан нь Америк орноос эрдэм чадал хэтийдсэн хоёр, гурван эрдэмтнийх нь нэгийг булаан одсон юм. Висконсины уугуул иргэн ноён Күртин нэгэн цагт Засгийн газрын дипломат албанд хүчин зүтгэж байсан боловч түүний хамгийн гол хөдөлмөр бүтээл бол утга зохиолын салбарт байсан юм. Ямарваа хэлийг сурах ер бусын авьяас, найруулан бичих өөрийн гэсэн өвөрмөц чадвар, үлэмжийн их хичээл зүтгэл, амарч сэгхийх чөлөөгүй нэр их хөдөлмөр, содон сонин улс үндэстэн хийгээд алс бөглүү нутгийн хүн ардыг танин мэдэх хүсэл тэмүүлэл, түүхэн чухаг үйл явдлын цаг үеийг эзэмдсэн домгийн мөн биеийг ухаж ойлгоход тусалдаг төсөөллийн аугаа билиг авьяас, энэ бүхний хослол нь түүний бүтээлийг онцлог содон үнэ цэнэтэй болгож өгдөг юм.

Сиенкиевичийн польш өгүүллэгүүдийн гайхалтай орчуулга, ялангуяа тэдний дотроос дундад зууны Польш орон, түүний Тартар, Швед болон Германтай хийсэн тэмцлийг өгүүлсэн хэсэг нь ямар ч хүнийг тэргүүн зэргийн нэр хүндтэй болгоход хангалттай билээ. Нэмж хэлэхэд, тэр бээр Энэтхэг, Селтик болон бусад ардын аман зохиолд холбогдох цохон тэмдэглүүштэй бүтээлүүдийг туурвисан. Гэвч түүний хийсэн бүтээсэн бүхний дунд хүчирхэг Их Монгол Улсын мандан бадарсан хийгээд унан доройтсоныг өгүүлсэн судалгаануудаас илүү чухал нь үгүй юм. Онцгой энэхүү талбарт түүний энд хүрэх өөр ямар ч Англи, Америк эрдэмтэн үгүй билээ.

Үнэндээ, Америк болон Английн хамгийн шилдэг эрдэмтэд дэлхийн түүхэнд онцгой байр суурь эзэлдэг Монголчуудын байлдан дагууллын тухай хөмөрсөн тогооны доторх шиг үл мэдэгдэх чухаг зүйлийг олж мэднэ гэдэг гайхамшгийн дээд. Эдгээр бүтээлийг туурвигч олноо алдар нэр түгсэн энэ англи эр хэдхэн жилийн өмнө XIII зууны тухай нэгэн сэтгэлд хоногшиж эссе бичсэн бөгөөд үүнээс нь түүний өргөн мэдлэг, түүхэн үйл явдлыг ухаж ойлгох чадвар, тухайн үеийг судлахад зарсан үлэмжхэн цаг хугацаа тодорхой харагддаг. Хэдий эссе бичигч бээр дурдаагүй боловч, XIII зууны хамгийн гайхамшигтай үйл хэрэг болох Шар тэнгисээс Адриатын тэнгис, Персийн булан хүртэлх газар орныг хамран тархсан Монголчуудын аугаа сүр хүчин, Чингис хааны суу билгийн талаар огт мэдэхгүй байсан явдал үзсээр илэрхий болсон юм. Иймэрхүү үл мэдэхүй нь түүх гэдэг бол ердөө Европын түүх, Европын түүх бол зөвхөн Латин болон Тютон<sup>5</sup> Европын түүх гэж боддог Баруун европын соёл бүхий хүмүүсийн дундах уугуул хэлбэрүү үзлийн үүднээс авч үзвэл, Загалмайтны аян дайнаас хол давж, Европын талыг эзэлсэн Монгол-Тартаруудын байлдан дагуулал шиг үйл хэргийг мэдэхгүй байгааг бүхэлд нь уучлахад хангалттай бус. Энэ мэт нүд балай, чих дүлий явдал Саламис ази Европыг дагуулснаас хойших эхний үед болон Орос-Японы дайны үеэр цөөнгүй хийдэг байсан шиг тиймэрхүү учир утгагүй хөгийн эш тайлбарыг байж болохуйц хэмээн үздэг эрдэмтэн судлаач бус ер энгийн хүмүүсийн дунд мэдээж хэрэг байсан бөлгөө. Баримтаас үзвэл, өнөөгийн цагаан арьстнуудын буюу Европчуудын цэргийн засаглал ердөө гурван зууны хэрэг явдал аж. XIII зууны эхнээс XVII зуун хүртэлх дөрвөн зууны туршид Монгол Түргийн цэрэг дайчид Европын өстөн дайснуудтайгаа хийсэн ямарваа тулаанд ихэнхдээ ялан дийлж, байнга л халдан довтлогч, байлдан дагуулагчийн дүрээр гарч ирж байв. Тэдгээр өдрүүдэд Европт Чингис хаан, Доголон Төмөр, Бажазет, Селим, Амураг, Бабер, Акбар нар шиг тийм

<sup>5</sup> Тютон (Teuton) – Христийн тооллын өмнөх 4-р зууны үед Ютландад амьдарч байсан Германчуудын нэг хэсэг.

хүчирхэг чадварлаг нударга, тийм далайцтай байлдан дагуулалд хүрсэн удирдагч байгаагүй юм.

Чингис хааны жолоог нь атгасан Монголчуудын сүр хүчний мандан бадрал бол санаанд авсаар багтамгүй, чихээр сонсоод итгэмгүй бөгөөд зургаан зууны өмнөх Арабуудынх шиг дэлхий дахиныг бүхэлд нь гайхашралд автуулсан билээ. XIII зуун гарах үед Чингис хаан ердөө олон монгол овог аймгийн овойж цойлсон алдар цуугүй энгийн жирийн ахлагчдын нэгэн байсан юм. Хань нөхөд зэрлэг бүдүүлгүүдийнхээ адилаар мал адуулан, морин дэл дээр амьдардаг эх нутаг болох Төв азийн тэгш талаас түүний болоод овог аймгийнх нь нэр хүнд өчүүхэн төдий ч халиагүй байв. Иргэншиж буй болоод бүрнээ иргэншсэн Европ юм уу Азийн орнуудад түүнийг таньж мэдэх эсвэл түүнээс эмээн сэрэмжлэх ч үгүй байлаа. Үүнийг үлгэрлэвэл, эдүгээ цагийн соёл иргэншилт дэлхийд өнөөдөр Сенөүсси<sup>6</sup> юм уу Сахарын өмнөд хязгаарын хар маади<sup>7</sup> нарын тухай хэн мэдэж, хэнд тэднээс болгоомжлох сэтгэл төрөхтэй агаар нэгэн. Тэр үед Европ дахин Ази эсвэл Африкийн зүгээс ирж болзошгүй түрэмгийллийн тухайд айдсын сүүдэр ч үгүй байсан цаг. Испанид Мооруудын<sup>8</sup> хүчин ягтаа тултал буурав. Франкүүд<sup>9</sup> болон Венецийнхин<sup>10</sup> Константинополийг<sup>11</sup> авч, буруу номтны эсрэг Европын хуучин цайз хэрмийг устгах үед ёрын Загалмайтны IV аян дайнаас болж загалмайтнуудын оршихуй сэтгэл, итгэлээ лавтайяа алдсан нь үнэн. Гэвч загалмайтны аян дайнд амь алдсан Барбаросса хаан Бага Азийн Селжүк Түркүүдэд бүрмөсөн дийлдэж, Ерусалемийг алдсан боловч гайхалтай сод цэцэн II Фредерик хаан “дэлхийн гайхамшиг”-ийг эгүүлэн авсан юм. Оросын славууд сулавтархан холбоонд нэгдэж, дорно тийш алгуурхан тэлж, нутаг нутгийн Фин хүмүүсийн дунд Москвагийн жишигээр суурьшиж байв. Унгар болон Польш агуу дайнд хаант улсууд байсан боловч Польш гүрэн бүрэн хүчирхэгжтэлээ хоёр зууныг элээжээ. Калифууд<sup>12</sup> Багдадыг захирсаар, Энэтхэгт Мохаммедүүд Ражпүттай тулалдаж, Хятадын эзэнт гүрэн Европын аль ч үндэстнээс соёл иргэншил, цэргийн хүчний хувьд магадгүй хол давуу болсон байлаа.

Ийм дэлхий ертөнцийг Монголчууд донсолгосон юм. Чингис хааны үйл хэрэг, бодлого эхний хэдэн жил овог аймгаа нэгтгэх, дараагаар нь ойр зэргэлдээ бүхий л овог аймгуудыг эрхшээн засахуйд чиглэж, энэ нь XIII зууны эхний арван жилд биеллээ олжээ. Зэрлэг морьтон ардын дундах тэдний засаг засаглал маргаангүй бодит зүйл байлаа. Тэр бээр бүхий л догшин ширүүн дайснууд, хүсэл зарлигийг хүлцэн сөгдөж эс дагагсдыг хядаж, харин үнэнч боол байж, үг зарлиг бүрийг өчүүхэн ч эргэлзэлгүй хүч чадал, эр зориггоо шавхан амь бие хайрлалгүй

<sup>6</sup> Сенөүсси – (Senoussi/ Senussi) - 1837 онд Аугаа Сайид Мухаммад ибн Али ас Сенүссигийн Мекка (Саудын Арабын Макках муж дахь Исламын шашинтны ариун хот )-д байгуулсан Ливи, Судан дахь лалын улс төр-шашны давхарга.

<sup>7</sup> Маади – (Mahdi) Хөтөч гэсэн утгатай үг бөгөөд Исламын шашны зөн бэлгэт аврагчийг хэлнэ. Лалын шашинтнууд маади нар үнэнч шударга ёсыг эгүүлэн авчирч, ертөнцийг төгс төгөлдөр болгоно гэдэгт итгэдэг.

<sup>8</sup> Моорууд – (Moors) 8-р зуунд Иберийн хойг буюу одоогийн Испани, Португалыг эзэлж байсан Араб болон Бербер угсаа холилдсон Баруун хойт африкийн лалын шашинтнууд.

<sup>9</sup> Франкүүд – (Franks) 6-р зуунд Гоолыг эзэлж байсан Германчууд.

<sup>10</sup> Венецийнхин – (Venetians) Венецийн оршин суугчид.

<sup>11</sup> Константинопол – (Constantinople) 330-395 онд Ромын эзэнт улсын, 395-1204, 1261-1453 онд Bizantын буюу Зүүн Ромын эзэнт улсын, 1204-1261 онд Латины эзэнт улсын, 1453-1922 онд Оттоманы эзэнт улсын нийслэл байсан. 1930 онд албан ёсоор Истанбул хэмээн нэрлэсэн.

<sup>12</sup> Калифууд – (Caliphs) Лалын шашинтны толгойлогч.

ёсчлон биелүүлэх хүмүүсийг ивээлдээ авч байв. Хамгийн сүр хүчит морьт харваач, морьт сэлэмч цэргийг яаравчлан байгуулж, өрнө, дорно, өмнө зүгт илгээж, түүний болон залгамжлагчдынх нь байлдан дагуулсан газар нутаг хил дамнан өргөжин тэлсээр байжээ. Ази болон Европт цэрэг дайн хүрэхээс өмнө хоёр үе өнгөрөх зуур мэгдэж цочирдсон бүхэн аймшигт Монгол морьтод, тэдэнд хүчин зүтгэж буй холбоотон угсаа гарал нэгт Түрэг-Тартаруудыг нэгэнтээ хүлээн зөвшөөрсөн байлаа. Тоогоор цөөн байлдан дагуулагчид нийт хүн төрөлхтөнд маш их хор хөнөөл учруулж байв. Монголчууд хатуу догшин, эрэлхэг зоригтой, тэсвэр хатуужилтай байсан. Тэдний дунд тухайн цагт Азийн ихэнх хэсэг дэх шиг Несториан христүүд байсан ч, бөө мөргөлтнүүд зонхийг эзэлж, сүсэг бишрэл, ёс суртахууны соёл нь XIX зууны Апаче<sup>13</sup>, Команче<sup>14</sup> нарынхтай адил байв. Тэд Команче, Апаче нараас өөрсдийг нь хүчирхэг давуу болгож өгдөг цэргийн зохион байгуулалтаараа ялгардаг ч, нөгөө талаас үзвэл тийм ч хөгжингүй хүмүүс байгаагүй бөгөөд соёл иргэншилт ард түмнүүд эрхшээлд нь автаж аймшигт хувь зохиолыг амсаж байсан нь өнөө цагийн хүмүүс нэг мэдэхэд Апаче овгийнхонд эзлэгдсэн лүгээ адил хэрэг болой. Монголчуудын өршөөлгүй хүчирхийлэл урьд хожид байгаагүй өргөн цар хүрээг хамарч байв. Мусулманчууд тэднээс Загалмайтнуудаас илүүгээр айж эмээж байв. Тэд Калифыг мухатгаж, Багдадыг Орос, Мажарын хот суурины адилаар тонож байв. Эсэргүүцэн боссон Түрэг овог аймгуудыг хайр найргүй нухчин дарж, үүгээрээ Европ дахинд аливаа эсэргүүцлийг хэрхэхээ харуулсан юм. Тэд дайн тулаанд санаанд багтахын аргагүй хурц эрэлхэг, аяны уртад эцэж цуцахыг үл мэдэх, алжаал ядрал, зовлон зүдгүүрээс халирч няцдаггүй, илд нумын эрдэмд эгнэшгүй чадварлаг байжээ. Халдаар ирэхээс нь өмнө айдас хүйдэст автсан байсан Европчуудад тэдгээр бохирч суудаг, онигор нүдтэй, шөрмөслөг морьтнууд “нохойн хоншоор мэт нүүртэй”, ад чөтгөр мэт аймшигтай зэвүүн, энгийн хүн төрөлхтөн эсэргүүцэж чадамгүй санагдаж байлаа. Тэд Хятадыг эзэлж, Монгол хүй улсын хаан сэнтийд залрав. Энэтхэг тэдний ач үрд эзлэгдэж, түүнчлэн Их Монгол Улсыг байгуулав. Перс мөн л эрхшээлд нь оров. Тэдний цэрэг дайчид, морин дэл дээрх баатар эрс бүхэн итгэхийн аргагүй алс хол замыг туулж, эсэргүүцэн боссон болгоныг устгаж байлаа. Оросыг уулгалан дарж, морьдын туурайн доор газар шороо цуст балчиг намаг болон гишгэгджээ. Мажарыг ганцхан тулаанаар бут цохин, нутаг дэвсгэр дээгүүр нь өргөн улаан шан татаж, хааныг нь улсаа орхин дүрвэхэд хүргэжээ. Польшийг дайран өнгөрч, Сайлижиа<sup>15</sup> дахь Хойд Германы язгууртан баатруудыг устгав. Баруун Европ өөрийгөө хангалттай хамгаалж чадахгүй байх байсан ч, аз түшихэд төв цэгээс хэт алслагдсаны улмаас Монголчуудын довтолгоонд өртсөнгүй. Монголчуудын байлдан дагууллыг таслан хязгаарлах Загалмайтны юм уу Европын цэргийн хүчин байгаагүй бол өрнө зүгт Египет дэх Түрэгийн Мамелүкүүд<sup>16</sup>, дорно зүгт хорин жилийн дараа Японы цэргийн хүчин зогсоосон юм.

Монголчуудын хоёр үеийн туршид, дорно зүгт агчид бүхэлдээ Бүддийн, өрнө зүгийнхэн Исламын шашинтан болж, баруун этгээдийн жинхэнэ Монголчууд аажимдаа үгүй

<sup>13</sup> *Апаче* – (Apaches) Америкийн нэгдсэн улсын баруун өмнөд цөл рүү нүүсэн Атабаскан аймгийнхан. 1861-1886 онд Америктай хийсэн тулаанд ялагдаж, Оклахомад суурьшжээ.

<sup>14</sup> *Команче* – (Comanches) Анхандаа Вёмингоос Техас хүртэлх газар нутагт амьдарч байсан Шошонеан аймгийнхан. Одоо Оклахомад суурьшсан.

<sup>15</sup> *Сайлижиа* - (Silesia) Чулуун нүүрс болон төмрийн хүдрийн баялаг нөөцтэй Төв Европын газар нутаг бөгөөд ихэнх хэсэг нь Польш улсад хамаардаг. Дундад зууны үед Ариун Ромын эзэнт улсын бүрэлдэхүүнд асан Герман хэлтнүүд нүүж ирсэнтэй холбоотойгоор Сайлижиад Германы соёл заншлын нөлөө давамгайлж байжээ.

<sup>16</sup> *Мамелүкүүд* – (Mamelukes) Мусулман шашинд орсон, дундад зууны үед Мусулманы Калифууд, Аюубидын Султануудад зүтгэж байсан боол цэргүүд.

болж, ялан дийлж эзлэн авсан Түрэг аймгууддаа уусаж байлаа. Тартарууд хэмээгдэх эдгээр Түрэг аймгууд хоёр зуу гаруй жилийн турш Оросыг аймшигтайгаар, айдас хүйдэс, цусанд авахуулан боолчлон эзэгнэж байсан нь үндэсний ухамсарт гүн гүнзгий хадагдан үлдсэн билээ. Оттоман түркүүд<sup>17</sup> Константиноплийг эзлэн авч, мандан бадрахын оргилд хүрч, Тартаруудын хүчин буурснаас хойш гучин жил болтол Оросууд зовлон зүдгүүрийн дөнгөнөөс ангижраагүй юм. Польш улс хүчирхэгжиж, өргөн уудам нутаг дэвсгэр нь Балтийн тэнгисээс Хар тэнгисийг хүртэл тэлэв. Энэ нь Мускови<sup>18</sup>-оос хол илүү чухал байлаа. Нэгдүгээр Элизабет<sup>19</sup>-ийн үеийн аялагч Финес Морисон<sup>20</sup>-ыг “Замын тэмдэглэл”<sup>21</sup>-ээс бид Түрк, Мажарууд эзлэгдсэний дараагаас Герман юм уу бусад аль ч улс үндэснийхээс илүүгээр Польшийн цэргийн хүчнээс айж эмээдэг байсныг мэдэж болно.

Монголчуудын далайсан байлдан дагуулах ташуур санаа бодлоос хэтийдсэн аймшигтай байсан тул аливаа нэгэн газар орон хэдий хэсэг зуур эрхшээлд нь автсан байлаа ч, түүнээс үлдсэн дурсамж урт удаан хугацааны турш гүн ул мөрөө үлдээжээ. Энэ нь Зүүн Европын зарим сүмүүдэд “Эзэн минь, биднийг Монголчуудын уур хилэнгээс ангижруулж хайрла” хэмээн залбирах болсноос хойш удалгүй тохиолдсон юм. Монголын цэрэг дайлан авах боломжийг авчирдаг, удирдагчийн мөн биеийг үл онцгойлох шоргоолж мэт, зөгий мэт нэгдмэл хамтын хүчээ боловсруулан хөгжүүлж байлаа. Францын нэгэн зохиолч энэхүү Монголчуудын аугаа “нэргүй ялалтууд”-ыг Тартар Төмөр юм уу Тамерлэйн гэдгээр нь бидний сайн мэддэг Түрэгийн догшин байлдан дагуулагчийн цэвэр хувийнх нь их амжилттай маш оновчтойгоор сөргүүлэн тавьсан байдаг. Монголчууд эзлэн авсан улс орондоо тогтоосон иргэний засаг захиргааны хэв байдлыг Хятадаас авч, захиран суусан газар дахь хятадын хүнд суртлын жолоодлого нь хүн ардыг бараг монгол цэргүүдийн зэрлэг балмад, хазааргүй харгислал шиг хорсгон залхааж байв. Монголын эзэнт гүрэн тусгаар улсуудад хуваагдсаны дараагаар аажимдаа аль нэг улс орон дахь шууд эрх мэдлээ бага багаар алдаж эхэлсэн ч, тэдний байлдан дагуулал далайцтай болоод ноцтой боломж бололцоогоор ханасан, тухайн үедээ гайхамшигтай гоц содон явдал байлаа. Монголын ард түмний түүхийн талаарх бүрэн мэдлэг нь Зүүн Европ болоод Азийн хөгжил мандлыг ойлгоё гэсэн хэн бүхэнд зайлшгүй чухал болно. Ийм түүхийг бичиж туурвихад Жеремиа Күртин шиг тэнцэх англи зохиолч үгүй билээ.

Теодор Рүүзвелт  
1907 оны 9 сарын нэгэн,  
Сагамор Хилл<sup>22</sup>.

<sup>17</sup> *Оттоман түрк* – (Ottoman turk) I Османы харьяан дахь түрэг овог аймгийн нэг. Оттоманы эзэнт улсыг I Осман тохинуулан байгуусан ба 1281-1923 онд оршин тогтнож байв. 1453 оны 5 сарын 29-нд II Мехмед султан Константиноплийг эзлэн авчээ.

<sup>18</sup> *Мускови* – (Muscovy) XIII-XVI зууны үед оршин тогтнож асан Оросын нэгэн ванлиг. Москва хот нийслэл нь байжээ.

<sup>19</sup> *Элизабет* – Elizabeth I (1533-1603) Англи болон Ирландын хатан хаан. 1558 оны 11 сарын 17-ноос 1603 оны 3 сарын 24-нд насан эцэслэх хүртлээ төр улсаа удирдан жолооджээ.

<sup>20</sup> *Финес Морисон* – (Fynes Morison /Morison, 1566-1630) Английн нэрт аялагч, зохиолч тэр бээр Европ, Палестин, Баруун өмнөд Азийн хойгоор олон жил аялжээ.

<sup>21</sup> *Замын тэмдэглэл* – (An Itinerary) Финес Морисон өөрийн хийсэн аялалын тухай бичиж 1617 онд хэвлүүлсэн ном. “Замын тэмдэглэл”-ийг угтаа таван цуврал гаргахаар зорьж байсан ч гурав нь л хэвлэгджээ.

<sup>22</sup> *Сагамор Хилл* – (Sagamore Hill) Теодор Рүүзвелтийн гэр. Рүүзвелт 1886 оноос 1919 оны 1 сард насан эцэслэх хүртлээ энд сууж байв. Рүүзвелтийг ерөнхийлөгч байх үед буюу 1902-1909 онд Сагамор Хиллийг “Зуны Цагаан Ордон” (Summer White House) гэдэг байжээ.